



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/535

Ховд

“Ховд брэнд бүтээгдэхүүн” шалгаруулсан
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 74 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ховдын хөгжил-2019 ” үзэсгэлэн худалдаанд оролцож Ховд аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан хавсралтанд заасан аж ахуйн нэгжийн нэрийн бүтээгдэхүүнүүдэд гэрчилгээ мөнгөн шагнал олгож, брэнд бүтээгдэхүүний тэмдэгт хэрэглэх эрх олгосугай.

2. “Ховд брэнд бүтээгдэхүүн”-ээр шалгарсан нэрийн бүтээгдэхүүнийг аймгийн хэрэгцээт байгууллагууд шууд худалдан авалтын гэрээ байгуулах, гадаад дотоодын зах зээлд суртачлах ажлыг дэмжиж ажиллахыг ажлын хэсгийн дарга Л.Жаргалсайхан /-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



D/Zax-A/535-Da

00 02875